

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/128/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: teqshdelqerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038-3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.11 № 01/01
танай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.НЯМХАНД ТАНАА**

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн болон сумын 100 жилийн ойн хандиваар ирсэн 295,243.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй 2,199.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, орлого төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 3 зөвлөмж хүргүүлээ.

Бусад асуудлын хэсэг

Төмөрбулаг сумын Засаг даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 94.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/Төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	217,293,037.15	360,697,122.43
33	АВЛАГА	23,335,022.15	24,831,217.43
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	101,695.28
33300	Татаас, санхүүжилтийн авлага	23,335,022.15	21,029,522.15
335	Бусад авлага	00.00	3,700,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	3,700,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	193,958,015.00	335,865,905.00
351	Түүхий эд материал	5,926,150.00	5,926,150.00
35110	Тусгай зориулалттай материал	5,926,150.00	5,926,150.00
354	Хангамжийн материал	186,991,865.00	327,304,755.00
35410	Бичиг хэргийн материал	2,417,500.00	1,350,500.00
35420	Аж ахуйн материал	15,959,648.00	16,899,558.00
35430	Сэлбэг хэрэгсэл	9,787,400.00	12,217,400.00
35450	Барилгын засварын материал	2,863,400.00	713,400.00
35470	Бусад хангамжийн материал	155,963,917.00	296,123,897.00
35600	Мал амьтад	1,040,000.00	2,635,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,220,083,975.08	1,194,420,324.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,220,083,975.08	1,194,420,324.28
392	Биет хөрөнгө	1,192,249,344.26	1,151,990,693.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	538,959,934.00	533,399,323.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-128,440,012.13	-141,941,736.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	340,839,133.00	329,605,833.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-98,826,274.73	-119,477,833.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	209,456,457.08	209,733,499.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-109,090,178.46	-102,739,680.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,886,194.00	48,728,370.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,473,905.73	-16,304,054.48
39209	Зам, гүүрийн байгууламж	390,300,254.91	390,345,254.91
39210	Хуримтлагдсан элэгдэл	-180,389,449.82	-203,753,369.82
39214	Бусад үндсэн хөрөнгө	280,634,800.00	338,727,725.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-64,607,607.86	-114,332,637.24
393	Биет бус хөрөнгө	27,834,630.82	42,429,630.90
39301	Програм хангамж	2,680,000.00	2,425,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,019,166.44	-1,169,166.36
39303	Бусад биет бус хөрөнгө	27,173,797.26	41,173,797.26
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,437,377,012.23	1,555,117,446.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,564,008.74	15,535,405.14
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,564,008.74	15,535,405.14
413	Өглөг	3,564,008.74	15,535,405.14
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,549,460.70	00.00
4136	Бусад өглөг	14,548.04	15,535,405.14
41361	Байгууллагад төлөх өглөг	14,548.04	14,279,905.14
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	1,255,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,433,813,003.49	1,539,582,041.57
51	Засгийн газрын хувь оролцоо	1,433,813,003.49	1,539,582,041.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	415,830,761.84	415,830,761.84
51101	Өмч: - төрийн	415,830,761.84	415,830,761.84
512	Хуримтлагдсан үр дүн	949,756,521.66	1,055,940,729.74
51210	Өмнөх үеийн үр дүн	949,756,521.66	953,003,037.99
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	102,937,691.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	68,225,719.99	67,810,549.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,437,377,012.23	1,555,117,446.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	228,765,000.00	299,443,766.93
120	Нийтлэг татварын бус орлого	228,765,000.00	299,443,766.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	228,765,000.00	299,443,766.93
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	208,265,000.00	152,958,786.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	20,000,000.00	142,284,980.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	3,700,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,074,716,877.00	1,051,726,971.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,443,777.00	14,748,171.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,808,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,180,947.00	10,011,671.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,454,830.00	4,736,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	999,273,100.00	1,036,978,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	999,273,100.00	1,036,978,800.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,303,481,877.00	1,351,170,737.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,225,798,870.48	1,248,233,046.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,087,340,161.66	1,233,008,164.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	671,893,861.68	804,930,029.11
210101	Үндсэн цалин	359,621,900.19	424,795,451.59
210102	Нэмэгдэл	288,304,041.49	296,289,147.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	41,700,629.59
210104	Урамшуулал	23,967,920.00	42,144,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,778,900.00	100,063,579.80
210201	Тэтгэврийн даатгал	56,995,120.40	69,636,678.49
210202	Тэтгэмжийн даатгал	6,688,965.60	7,631,393.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,346,700.00	4,271,826.73
210204	Ажилгүйдлийн даатгал	3,343,382.80	3,959,081.51
210205	Эрүүл мэндийн даатгал	13,404,731.20	14,564,599.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,977,664.37	43,070,987.07
210301	Гэрэл, цахилгаан	4,842,841.97	8,386,164.67
210302	Түлш, халаалт	34,953,622.40	34,503,622.40
210303	Цэвэр, бохир ус	181,200.00	181,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,543,138.00	45,588,296.00
210401	Бичиг хэрэг	5,856,000.00	4,669,620.00
210402	Тээвэр, шатахуун	32,117,138.00	21,749,236.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,254,600.00	6,514,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	650,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,105,400.00	11,475,190.00
210408	Бараа материал акталсны зардал	2,810,000.00	530,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,344,500.00	21,462,000.00
210604	Урсгал засвар	2,344,500.00	21,462,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,500,000.00	2,850,000.00
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00	2,850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,188,053.00	10,990,335.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,840,155.00	9,574,937.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	354,600.00	161,760.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,500.00	86,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	56,900.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	827,500.00	1,056,000.00
210807	Газрын төлбөр	905,398.00	78,438.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	225,114,044.61	204,052,937.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,861,795.00	14,483,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	962,000.00	5,450,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	173,290,249.61	184,119,937.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,458,708.82	15,224,881.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,878,651.00	3,951,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,829,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,049,451.00	3,951,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	52,580,057.82	11,273,381.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,580,057.82	11,273,381.47
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,225,798,870.48	1,247,703,046.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	77,683,006.52	102,937,691.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,966,666.60	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,966,666.60	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3,966,666.60	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	73,716,339.92	102,937,691.75

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,830,761.84	122,409,477.99	80,264,248.88	618,504,488.71
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	78,819,871.20	78,819,871.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	415,830,761.84	122,409,477.99	159,084,120.08	697,324,359.91
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	307,667,611.83	307,667,611.83
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,830,761.84	68,225,719.99	949,756,521.66	1,433,813,003.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	3,246,516.33	3,246,516.33
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	415,830,761.84	68,225,719.99	953,003,037.99	1,437,059,519.82
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-415,170.00	00.00	-415,170.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	102,937,691.75	102,937,691.75
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,830,761.84	67,810,549.99	1,055,940,729.74	1,539,582,041.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	500,000.00	500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	500,000.00	500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	500,000.00	500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,084,352,319.15	1,057,212,471.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,079,219.15	20,233,671.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,808,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,180,947.00	10,011,671.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,090,272.15	10,222,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	999,273,100.00	1,036,978,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	999,273,100.00	1,036,978,800.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,084,852,319.15	1,057,712,471.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	934,367,810.33	1,036,859,089.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	670,234,300.00	805,189,090.84
210101	Үндсэн цалин	357,962,338.51	425,251,303.79
210102	Нэмэгдэл	288,304,041.49	295,500,617.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	41,700,629.59
210104	Урамшуулал	23,967,920.00	42,736,539.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,778,900.00	100,396,675.69
210201	Тэтгэврийн даатгал	56,995,120.40	69,784,347.59
210202	Тэтгэмжийн даатгал	6,688,965.60	7,816,820.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,346,700.00	4,271,826.73
210204	Ажилгүйдлийн даатгал	3,343,382.80	3,959,081.51
210205	Эрүүл мэндийн даатгал	13,404,731.20	14,564,599.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,009,820.17	41,700,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,646,019.77	8,581,912.71
210302	Түлш, халаалт	33,182,600.40	32,618,087.29
210303	Цэвэр, бохир ус	181,200.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,449,300.00	22,936,850.00
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	2,036,500.00
210402	Тээвэр, шатахуун	22,478,700.00	12,483,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,803,600.00	6,514,250.00
210404	Ном, хэвлэл	17,200.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,918,400.00	898,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,231,400.00	1,004,700.00
2105	Нормативт зардал	00.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,342,000.00	24,892,000.00
210604	Урсгал засвар	10,342,000.00	24,892,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,500,000.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,890,040.00	14,494,723.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,369,642.00	13,140,325.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	354,600.00	161,760.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,500.00	86,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	56,900.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	995,000.00
210807	Газрын төлбөр	905,398.00	78,438.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,163,450.16	24,249,750.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,201,450.16	16,807,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	962,000.00	7,442,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,034,708.82	17,953,381.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,454,651.00	3,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,829,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,625,451.00	3,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	52,580,057.82	14,453,381.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,580,057.82	14,453,381.47
21	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	1,072,402,519.15	1,054,812,471.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,449,800.00	2,900,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,449,800.00	2,900,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,449,800.00	2,900,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,449,800.00	2,900,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,449,800.00	2,900,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-12,449,800.00	-2,900,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	/ төгрөгөөр / Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,050,422,800.0	1,025,705,418.5	24,717,381.5	97.1
132001	Орон нутгийн төсвөөс	1,050,422,800.0	1,025,705,418.5	24,717,381.5	97.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.0	500,000.0	0.0	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.0	500,000.0	0.0	100.0
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,050,922,800.0	1,026,205,418.5	24,717,381.5	97.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,050,922,800.0	1,026,205,418.5	24,717,381.5	97.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,046,122,800.0	1,023,005,418.5	23,117,381.5	97.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	811,844,100.0	805,189,090.8	6,655,009.2	99.2
210101	Үндсэн цалин	430,559,600.0	425,251,303.8	5,308,296.2	98.8
210102	Нэмэгдэл	304,912,300.0	295,500,618.0	9,411,682.0	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,875,000.0	41,700,629.6	8,174,370.4	83.6
210104	Урамшуулал	26,497,200.0	42,736,539.5	-16,239,339.5	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,198,700.0	100,396,675.7	1,802,024.3	98.2
210201	Тэтгэврийн даатгал	69,724,923.0	69,784,347.6	-59,424.6	100.1
210202	Тэтгэмжийн даатгал	8,118,497.0	7,816,820.4	301,676.6	96.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,059,220.0	4,271,826.7	-212,606.7	105.2
210204	Ажилгүйдлийн даатгал	4,059,220.0	3,959,081.5	100,138.5	97.5
210205	Эрүүл мэндийн даатгал	16,236,840.0	14,564,599.5	1,672,240.5	89.7

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,200,000.0	41,200,000.0	00.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.0	8,581,912.7	418,087.3	95.4
210302	Түлш, халаалт	32,200,000.0	32,618,087.3	-418,087.3	101.3
2104	Хангамж, бараа материалын зардал	33,752,700.0	21,136,850.0	12,615,850.0	62.6
210401	Бичиг хэрэг	3,500,000.0	2,036,500.0	1,463,500.0	58.2
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.0	11,483,400.0	3,516,600.0	76.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,600,000.0	5,714,250.0	1,885,750.0	75.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,352,700.0	898,000.0	3,454,700.0	-79.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300,000.0	1,004,700.0	2,295,300.0	30.4
2105	Нормативт зардал	1,000,000.0	1,000,000.0	00.0	00.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.0	1,000,000.0	00.0	00.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,000,000.0	23,960,000.0	4,040,000.0	85.6
210604	Урсгал засвар	28,000,000.0	23,960,000.0	4,040,000.0	85.6
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
210702	Дотоод албан томилолт	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,627,300.0	13,383,052.0	3,244,248.0	80.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,877,300.0	12,028,654.0	848,646.0	93.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.0	00.0	1,000,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.0	161,760.0	138,240.0	53.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.0	86,200.0	263,800.0	24.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.0	33,000.0	67,000.0	33.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.0	995,000.0	505,000.0	66.3
210807	Газрын төлбөр	500,000.0	78,438.0	421,562.0	-84.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,500,000.0	14,739,750.0	-5,239,750.0	155.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.0	14,347,250.0	-6,347,250.0	179.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.0	392,500.0	1,107,500.0	26.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,800,000.0	3,200,000.0	1,600,000.0	66.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,800,000.0	3,200,000.0	1,600,000.0	66.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.0	3,200,000.0	1,600,000.0	66.7
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,050,922,800.0	1,026,205,418.5	24,717,381.5	97.6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	3	3	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	Гүйцэтгэл	
		20,233,671.00	

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,011,671.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,222,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,748,171.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,753,671.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	500,000.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	932,000.00
210604	Урсгал засвар	932,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,011,671.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,011,671.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,510,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,460,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,050,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,180,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,180,000.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,233,671.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын илрүүлэлт

5.1 Аудитаар нийт 125,684.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайланд 2,900.0 мянган төгрөгийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг тайлагнаагүй,
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 122,784.3 мянган төгрөгийн худалдаж авсан үндсэн хөрөнгө болон үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийн дүнг зөрүүтэй тайлагнасан алдааг тус тус залрууллаа.

Аудитаар 6,179.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 3 зөвлөмж хүргүүллээ.

5.2 Төлбөрийн акт

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1. Байгууллагын даргын тушаалаар мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн Ж.Нямхандад ёс зүйн дэд хорооны даргын ажлыг хавсран гүйцэтгэсэн гэж сар бүр үндсэн цалингийн 10 хувиар тооцож 2025 оны 1-3 сард 306.6 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10.2 "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас 2025 оны 12 сард байгууллагад хэрэгцээ шаардлагагүй 1,893.0 мянган төгрөгийн материал худалдан авч өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх; нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохимжтой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой

Илрүүлэлт:

Бохир соруулсны орлого, Усны мөнгө зэрэг орлого нь жил бүр төвлөрдөг, төлөвлөгдөх боломжтой орлогууд байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 44.4."Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ." гэсэн заалттай нийцэхгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Урьдчилан төлөвлөх боломжтой өөрийн үйл ажиллагааны орлогыг тухайн жилийн төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

2.1 Илрүүлэлт:

Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь үйл ажиллагааны төлөвлөгөө боловруулаагүй, хөрөнгийн ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.1.3 "Зөвлөл нь тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор байгууллагын удирдлагаар батлуулна", 2.2.2 "Зөвлөл нь төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй" гэсэн заалттай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөөг баталж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллах

3.1 Илрүүлэлт:

Байгууллагын дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөө тайлантай танилцахад байгууллагын бүх үйл ажиллагааг хамраагүй, хяналтыг үр дүнтэй гүйцэтгээгүй, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 2.3 "Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино" гэсэн заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын дотоод хяналтын нэгжийг журмын дагуу ажиллуулж, эрсдэлээс урьдчилах сэргийлэх

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруула агүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланг алдаатай илэрхийлсэн.	1	2,900.0			1	2,900.0	1	2,900.0		
ҮХ-ийн тодруулгыг алдаатай илэрхийлсэн.	1	122,784.3			1	122,784.3	1	122,784.3		
ДҮН	2	125,684.3			2	125,684.3	2	125,684.3		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урамшуулал илүү олгосон	1	306.6	1	306.6								
Хэрэгцээгүй бараа материал бэлтгэсэн	1	1,893.0	1	1,893.0								
Байгууллагын өөрийн орлогын төлөвлөлт дутуу	1	3,980.0					1	3,980.0				
Дүн	3	6,179.6	2	2,199.6			1	3,980.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/


Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дотоод хяналтын нэгж хангалтгүй ажилласан	1	0					1	0
Өмч хамгаалах зөвлөл ажиллаагүй	1	0					1	0
Дүн	2	0					2	0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1			1				
2	Төсөл, хөтөлбөр									
3	ЗГТС									
4	ТТЗ									
5	ТЕЗ									
	НИЙТ	1	1			1				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

АХЛАХ АУДИТОР



Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: